## 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГАДААД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

### II. Зочид, төлөөлөгчид

| Д/д | Улс, хот | Албан тушаал | Хүний тоо | Хугацаа | Зорилго | Төсөв | Үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сингапур | "Эс Ти Инженеринг" компани | 3 | 2022.05.09-12 | Төсөл хэрэгжүүлэх судалгаа хийх | - | Айлчлалын хүрээнд нийслэлийн хот төлөвлөлт, зохион байгуулалт, зам, тээвэртэй холбоотой чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцан эхний шатны судалгааг хийсэн. Цаашлаад 2022-2024 онд нийслэлд хэрэгжүүлэх Замын хөдөлгөөн зохицуулалт, төлөвлөлтийн нэгдсэн систем төсөлд ашгийн бус хамтын ажиллагааны хүрээнд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах саналыг ирүүлсэн. |

### III. Албан уулзалт

| Д/д | Улс, хот | Албан тушаал | Хүний тоо | Хугацаа | Зорилго | Төсөв | Үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | АНУ | "Оракл" компани | 4 | 2022.02.18 | Хамтран ажиллах санал танилцуулах | - | Тус компанийн зүгээс Улаанбаатар хотод сүүлийн үеийн дэвшилтэт сервер, тоног төхөөрөмж, хадгалалт, хамгаалалт, инженерийн систем, клауд үйлчилгээ, мэдээллийн систем хоорондын интеграци хийж холбох, аюулгүй ажиллагааг хангах, орчин үеийн дэвшилтэт камерын технологийг нэвтрүүлэхэд хамтран ажиллах санал тавьж харилцан санал солилцсон. |

### IV. Олон улсын Сургалт, семинар (товч тайлангийн хамт)

| Д/д | Зохион байгуулагч | Сэдэв | Хүний тоо | Хугацаа | Албан хаагчийн нэр | Албан тушаал | Хүрсэн үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Филиппин улс /цахим/ | Манила хотын Тээврийн газар | 5 | 2022.02.17 | RFID төхөөрөмжийг нэвтрүүлсэн талаарх туршлага судлах | - | Филиппин улс нь 2020 оноос эхлэн RFID төхөөрөмжийг төлбөртэй хурдны зам болон орох гарах хөдөлгөөнтэй товчоодод суурилуулж төлбөр, тооцоотой холбоотой харилцааг 90 хувь цахимжуулсан. Энэ хүрээнд Манила хотод RFID төхөөрөмжийг суурилуулахад тулгарсан бэрхшээл, иргэдийн хүлээлт, хандлага, анхаарах асуудал, хууль эрх зүйн орчин зэрэг асуудалд зөвлөгөө авч харилцан санал солилцсон. |

НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР